

## ЗҮҮН ХОЙТ АЗИ, БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Б. Балдоо

1992 оны 8 дугаар сарын 25-27-нд Оросын Приморийн хязгаарын Владивосток хотод "Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болов. Бага хуралд бүс нутгийн АНУ Монгол улс, ОХУ, БНАСАУ, БНСУ, БНХАУ, Япон улсын төлөөлөгч 100 шахам эрдэмтэн, улс төрч-дипломатч, бизнесмен оролцов. Бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэм, эдийн засаг, улс төрийн уур амьсгал, Оросын Алс Дорнод, Умард Солонгос, Зүүн хойт Хятад, Монголыг хөгжүүлэх төлөвлөгөө, бүс нутгийн хамтын ажиллагаанд хандах ацан хандлага, аж ахуйн салбарууд дахь хамтын ажиллагаа, хоршсон хөгжлийн үзэл баримтлал, олон талын хамтын ажиллагааны бүтэц гэсэн 6 асуудлын хүрээнд 20 гаруй илтгэлийг бага хурал сонсов.

Бага хурлыг зохион байгуулагч нь АНУ-ын Гавайн Дорнод-Өрнөд төв, Оросын Приморийн хязгаарын захиргаа, Владивостокийн Номхон далайн далай судлалын институт, ивээн тэтгэгч нь Японы Сасакавын энх тайвны фонд, БНСУ-ын эрдэм шинжилгээний хоёр байгууллага байв.

Владивостокийн бага хурал нь Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны асуудал хэлэлцсэн 4 дэх чуулга байсан бөгөөд түрүүчийн гурван хурал нь БНХАУ-ын Чанчунд /1990, 1991/, БНАСАУ-ын Пхеньянд /1992. IV-Ү сар/ болжээ.

Зүүн хойт Азид /ЗХА/ улс төрийн уур амьсгал бүлээрч, эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх хандлага хүч авах болсонтой холбогдон ерээд он, түүнээс цааших хугацаанд Зүүн хойт Азийн бүс нутагт эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх бололцоо, тохиолдож болох потенциал бэрхшээлүүдийн талаар иж бүрэн судалгаа хийж бүтээлч маргаан, санал солилцлого явуулах явдал цаг үеийн тулгамдсан шаардлага болсон билээ.

Энэ чиглэлийн үйл ажиллагаа гурван жилийн өмнөөс эхэлж, эрдэм шинжилгээний цуврал бага хурлууд зохиогдох болсон. Эдгээр бага хурлыг АНУ-ын Гонолулу хотын Гавайн Дорнод-Өрнөд төв, Гавайн Ази-Номхон далайн институт, Зүүн хойт Азийн эдийн засгийн чуулга санхүүжүүлдэг бөгөөд энэ ажилд Зүүн хойт Азийн орон бүрийн янз бүрийн байгууллага оролцож ирлээ. Гавайн Дорнод-Өрнөд төв Ази Номхон далайн орнуудын хоорондын харилцааг сайжруулах үйлст анхлан хүчин зүтгэгсдийн нэг байсан юм. 1989 онд Дорнод-Өрнөд төв ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын салбартай хамтран Япон тэнгис, Охотскийн тэнгисийн асуудлаар Владивосток, Находкад уулзалт явуулж, дараа нь удаггүй ЗХУ-ын ГЯЯ ба ШУА-ийн дэмжлэгтэйгээр "Энх тайван, хамтын ажиллагаа, яриа хэлцэл" сэдэвт бага хурал зохиосон бөгөөд бага хурлын дэд хорооны илтгэлд Түмэн голын сав газар /Орос, Хятад, Умард Солонгос гурван улсын учл дагуу урсдаг Түмэн голын сав газарт/ бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлэх санал анх дэвшүүлсэн юм. 1990 онд Чанчун хотод "Зүүн хойт Азийн далайн эрэг орчмын районууд дахь бүсийн хамтын ажиллагаа" сэдэвт бага хурал Хятадын Жилин мужийн Засгийн газрын дэмжлэгтэй болж, Түмэн голын сав газрыг /"Алтан бэлчир" / хөгжүүлэх асуудалд гол анхаарал хандуулсан юм. Өнгөрсөн онд Чанчуны 2-р бага хурлаар

Зүүн хойт Ази, ялангуяа Түмэн голын сав газарт бүсийн хамтын ажиллагаа өрнүүлэх саналыг /БНАСАУ-ын оролцоотойгоор/ дахин нотолж энэ талаар засгийн газрын бус яриа хэлцэл хийж, судалгаа явуулахаар тогтсон аж. Энэ оны 4-р сарын сүүлч, 5-р сарын эхээр БНАСАУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Пхеньянд Түмэн голын сав газар, ЗХА-ийн хамтын ажиллагааны асуудал хэлэлцсэн бага хурал болж, хурлын төлөөлөгчдөд уг сав газар, түүний ойролцоохи 3 усан боомтыг танилцуулсан юм.

Цуврал бага хурлын дөрөв дэх нь 1992 оны 8 дугаар сарын 25-28-нд Владивосток хотод Оросын холбооны улсын Приморийн хязгаарын захиргааны дэмжлэгтэй болж, уг хурлыг санхүүжүүлэхэд Японы Сасакавагийн энх тайвны фонд, БНСУ-ын зарим байгууллага хандив өргөсөн ажээ.

Тус бага хуралд АНУ, БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, БНАСАУ, Монгол долоон орны 100 шахам эрдэмтэн, улс төрч-дипломатч, бизнесмен Гавайн Дорнод-Өрнөд төв ба Приморийн хязгаарын захиргааны урилгаар оролцов. Бага хурлын ажиллагааг Дорнод-Өрнөд төвийн дэд ерөнхийлөгч доктор Ли-Жей Чо удирдав. Бага хуралд Приморийн хязгаарын захиргааны тэргүүн В. Кузнецов, Оросын Холбооны улсын ГЯЯ-ны сайд А. Козырев, Оросын Холбооны Улсын Дээд Зөвлөлийн дарга Р. Хасбулатов нар илгээлт ирүүлжээ. Илгээлтүүдэд "Бүс нутгийг хөгжүүлэн цэцэглүүлэх зорилготой Умар Азийн бүсийн нутгийн шинэ хэв маягийн соёл иргэншлийг байгуулах бололцоо Зүүн хойт Азийн хамтын нийгэмлэгт байгаа" гэдгийг онцлон дурдаж, "Зүүн хойт Азийн одоогоор салангид байгаа эдийн засгуудыг ойртуулан, эдийн засгийн харилцан үйлдлийн илүү үр ашигтай зам мөрийг тодорхойлохын чухлыг тэмдэглэсэн байна.

Бага хурлын ажиллагааг өвөрмөцөөр төлөвлөн явуулсан байна. Хуралд бэлтгэх төлөвлөгөө нь зайлшгүй авч үзвэл зохих ерөнхий сэдвүүд, тэдгээрийг задалсан дэд сэдвүүдээс бүрдсэн бөгөөд дэд сэдэв нэгбүрээр илтгэгч, маргагч хоёрыг томилж, тэдгээрээр урьдчилэн бэлтгүүлжээ. Энэ төлөвлөгөөний үндсэн дээр бага хурал 3 өдрийн 6 хуралдаанаар 23 илтгэгч, мөн төдий орчим тооны маргагч нарын бэлтгэсэн материалуудыг сонсов. Хурлын төлөвлөгөөнд чөлөөт маргаан явуулахаар төлөвлөсөн боловч энэ ажилд цаг үл хүрэлцэв.

Бага хуралд тавьсан илтгэлүүд нь Зүүн хойт Азийн улс төр, нийгэм-эдийн засгийн орчин үеийн байдал, цаашдын хөгжлийн төлөвийн талаар сүүлийн үед хийсэн судалгааны дүн, нэгтгэн дүгнэсэн зүйлсийг тусгажээ. Үүнээс бага хурлын онцлог тал уриан гарсан бөгөөд тэр нь Зүүн хойт Азийн хөгжлийн асуудалд иж бүрэн хандаж, түүнийг харилцан уялдаатай олон чиглэлээр авч үзэн, санал бодлуудаа илэрхийлсэнд оршино.

Бага хурал хэлэлцэх зүйлээ: -бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэм, эдийн засаг, улс төрийн уур амьсгал: -Оросын Алс Дорнод, Умард Солонгос, Зүүн хойт Хятад, Монголыг хөгжүүлэх төлөвлөгөөнүүд, -бүс нутгийн хамтын ажиллагаанд хандах ацан хандлагууд, -аж ахуйн салбарууд дахь хамтын ажиллагаа, -хоршсон хөгжлийн үзэл баримтлалууд, -олон талын хамтын ажиллагааны бүтэц гэсэн зургаан үндсэн асуудалд бүлэглэв. Тэдгээрийн хүрээнд 23 илтгэл танигдсаны дотор бүсийн хамтын ажиллагааны нийгэм-эдийн засгийн уур амьсгал сэдвээр проф. Хашима /Япон/, улс төрийн байдлын сэдвээр проф. Скалаино /АНУ/, бүсийн харьцуулсан давуу талын сэдвээр проф. Кэшибэл /АНУ/, аж үйлдвэржилтийн сэдвээр проф. Секигучи /Япон/, Оросын Алс дорнодын сэдвээр доктор Менакер ба Алнев /Орос/, Олон улсын эдийн засгийн бүс сэдвээр проф. Кубаяни /Япон/, Зүүн хойт Хятадын сэдвээр инженер Ли Бин, Монголын сэдвээр эдийн засгийн сайд Олздор, бүсийн санхүүгийн хамтын ажиллагааны механизм сэдвээр доктор Сун Сан Пал /Солонгос/, олон талын хамтын ажиллагааны үзэл баримтлалын сэдвээр доктор Иванде /АНУ/ нар илтгэв.

Илтгэлүүдэд өнөөдрийн Зүүн хойт Азийн байдал, хөгжлийн явцад хуримтлуулсан турчлага, тулгамдсан зорилтуудтай холбогдсон чухал чухал асуудлуудад задлан шинжилгээ хийж олон талаас авч үзэв. Тус мэдээлэлд бага хурал дээр илэрхийлэгдсэн олон санал бодол, үндэслэлүүдээс бүс нутгийн нийгэм-эдийн засгийн үүр амьсгал, улс төрийн байдал ба хөгжлийн бодлого, олон улсын эдийн засгийн чөлөөт бүс гэсэн гурван бүлэг асуудлын зарим санаа, үндэслэлийг товч хөндөв.

Зүүн хойт Азийн өнөөгийн нийгэм-эдийн засгийн байдлыг түүхэн дэвсгэр дээр гаргаж, зуугаад жилийн зогсонги байдлын дараагаар Ази, Номхон далайн бүс нутгийг динамик эдийн засагтай болгон хувиргах өөрчлөлт 1950-60-аад онд өрнөдийн үйлдвэржсэн эдийн засгийн хурдан хөгжлийн нөлөөгөөр хэрэгжсэнийг тэмдэглэв. Шинээр үйлдвэржсэн эдийн засгууд буюу орнууд /Гонконг, Тайван, Сингапур, Өмнөд Солонгос зэрэг/ эдийн засгийн өндөр хөгжлийг олсон бөгөөд тэд нь Ази Номхон далайн эдийн засгууд 1970-80-аад онд хөгжлийн динамикаа хадгалахад нь тусалжээ. Шинээр үйлдвэржсэн эдийн засгууд /ШҮЭЗ/, Япон улс дотоодын хөрөнгө оруулалтаас илүүдэл хөрөнгө хуримтлуулах болж, түүнээ гадагш гаргах газрыг хайж, эхлээд Зүүн Ази, дараа нь Зүүн хойт Азийг сонгож авсан байна. Орчин үед Хятад, ЗХУ, Монгол зэрэг орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих чиглэлд анхны алхмууд хийж байгаа үйл явц илүүдсэн хуримтлал, өндөр технологитой Япон, ШҮЭЗ-ийн бусад орны бизнес эрхлэгчдийн анхаарлыг татаж байна гэсэн санаа илэрхийлэгдэв.

Зах зээл, нөөцийн хуваарилалт, төлөвлөлтийн тухай асуудлаар анхаарал татахуйц зүйл хурал дээр яригдав. Орчин үед улс орны эдийн засгийн бүх хэрэгцээг урьдчилан харж, орлого зарлагыг бүх зүйлээр нь яг таг тооцож чадахгүй гэдэг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөж байна. Иймээс БНХАУ, Монгол, ЗХУ-д төлөвлөлтийн тогтолцоонд өөрчлөлт оруулж байна. Төлөвлөлтийн өөр хэв маягт шилжих шаардлага аль хэдийнээ гарсан юм. Ийм өөр хэв маягийн төлөвлөлтийг Япон, Өмнөд Солонгос, Тайван болон зах зээлийн бусад эдийн засаг хэрэглэж хөгжил цэцэглэлд хүрсэн. Энэхүү "харуулагч" буюу "үзүүлэгч" гэж тодорхойлогддог өөр хэв маягийн төлөвлөлт нь улсын гар дахь баазын багахан хэсгийг хамран, үйл ажиллагааныхаа ихэнх хэсгийг хувийн секторын бааз дээр явуулдаг. Засгийн газар хувийн секторын тооцож үзвэл зохистой зорилт, баримтлах шугамыг заан өгч, тэдгээрийг хэрэгжүүлэхэд өөрийн санхүү, үйлдвэрлэл, гадаад худалдааны бодлогоо чиглүүлдэг. Засгийн газрын баримтлах бодлого шугамын гол зүйл нь хөгжлийн стратеги бөгөөд түүнд эдийн засгийн салбаруудад зорилго болгон заасан зүйлс тусгалаа олдог гэж проф. Ошим тэмдэглэв.

Зах зээлд шилжих тухай асуудал яригдах явцад хятадын эдийн засагчид "социалист зах зээлийн системийг" хөгжүүлж байгааг тэмдэглээд энэ систем нь хэдэн арван жилийн өмнө Оскар Ланге-гийн сурталчилж байсан үзэл баримтлалтай төстэй болохыг заав.

Өнгөрсөн жилүүдэд капиталист ертөнцөд хувьчлах үйл явц идэвхтэй явагдаж, ийм ажил Япон, Итали, Турк, Тайланд зэрэг оронд өрнөсөн юм. Социалист системд хамаарагдаж байсан Азийн орнуудад хувьчлах үйл явц явагдаж эхлэв. Энэ нь социалист системийн хувьд хялбар бүс зорилт юм. Энэ үйл явдлыг улсын үйлдвэрийн удирдлага төдийгүй, мөн ажилчин анги ч эсэргүүцэж магадгүй юм. Иймд Түмэн голын сав газарт байгуулах олон улсын эдийн засгийн чөлөөт бүсэд зах зээлчлэх, хувьчлах оролдлого хэрхэн хийгдэх нь сонирхолтой байх болно гэж бага хурал дээр тэмдэглэв.

Өнөөгийн олон улсын харилцааны байдал, түүний хөгжлийн хандлагын асуудлыг бага хурал авч үзэн задлан шинжилгээ хийсэн байна. Проф. Скалапниогийн бодлоор өнөөгийн олон улсын бодлогод гурван хандлага зонхилж байна.

Нэгдэх өргөн хандлага нь бүх улс орны тэргүүн зэргийн зорилго нь эдийн засгийг хурдан хөгжилд хүргэхтэй холбоотой. Эдийн засаг

өнөөгийн олон улсын харилцааны зонхилох хүч болсон. Эдийн засгийн сталинч сонгодог стратеги үеэ өнгөрөөж, төрийн зүгээс идэвхтэй дэмжлэг аасан зах зээлийн тогтолцоонд итгэх явдлыг нийтээр хүлээн зөвшөөрч байна. Хоёр ба олон талын төвшинд яриа хэлцэл, хэлэлцээний механизмыг хэрэглэх болж, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүд улс төрийн хил хязгаарыг дамнан байгуулагдах болжээ.

Хоёр дахь өргөн хандлага нь улс төрийн үлэмж нээлттэй байдал өөд тэмүүлэх ерөнхий хөдөлгөөнтэй холбоотой аж. Ази тивд ленинист, авторитар-плюралист, либерал ардчилсан гэсэн гурван улс төрийн тогтолцоо өнөөдөр байна. Либерал ардчилсан систем тогтоох туршилтыг /таван арван жилийн өмнөөс Японд нэвтрүүлсэн шиг/ өнөө үед Орос, Монгол, Өмнөд Солонгос, Тайланд хийж байгаа тухай хурлын илтгэлд дурдав.

Гурав дахь өргөн хандлага нь улс үндэстний хоорондын ба дотоод дахь харилцаа өөрчлөгдөн, олон улсын боллогын янз бүрийн хэлбэрүүдийн хослол буй болж байгатай холбоотой юм. Европ, түүний зах хязгаарыг багтаасан холбоотны бүтцээр тодорхойлогдон, АНУ ба ЗХУ-ын хоорондын дэлхийг хамарсан тэмцэл дээр суурилсан хуучин "дэг журам" төгсгөл болж байна. Ийнхүү хоёр туйлт гэж нэрлэгдэж байсан "дэг журам" үеэ өнгөрөөж, оронд нь олон туйлт гэж судлаачдын нэрлэсэн систем буй болж байна гэжээ.

Зүүн хойт Ази дахь эдийн засгийн хамтын ажиллагааны тухай асуудлыг бага хурал өргөн хүрээтэй авч үзэн, түүний ач холбогдол, бололцоо нөхцөлийн талаар нэлээд илтгэгч, маргагч нарын хэлсэн үгсэд дурдагджээ. Орчин үед улс хоорондын хоёр талын ба олон талын хамтын ажиллагаа өргөжихийн хамт энэ чиглэлийн олон улсын эдийн засгийн байгууллагууд буй болж, үйл ажиллагаагаа идэвхжүүлэн, мөн улс төрийн хил хязгаарыг дамнан гарс н, хэд хэдэн орны зөвхөн хэсгүүдээр хүрээлэгдсэн, байгалийн болон ажиглах хүчний нөөц, технологи болон капиталыг хослуулж дээд зэргийн дэвшилд хүрэхэд хувь нэмэр оруулахуйц тийм эдийн засгийн бүсүүд байгуулагдсан, байгуулагдаж байна. Өнөөдөр дэлхийн энд тэнд олон улсын эдийн засгийн чөлөөт бүсүүд буй болсон бөгөөд дотроо чөлөөт усан боомт ба худалдааны бүс, эдийн засгийн чөлөөт бүс, экспортын үйл явц гүйцэтгэдэг бүс, худалдааны чөлөөт бүс, импортын үйл явц гүйцэтгэдэг бүс, импорт ба экспортын үйл явц гүйцэтгэдэг бүс гэж зургаан төрөлд хуваагддаг ажээ.

Зүүн хойт Азид иймэрхүү бүсүүд үүсэх эхлэл тавигдсан байна. Хятадын Хуньчин анхны нээлттэй хот болж тэнд газрыг түрээсэнд өгөх болсон, Чанлинжид орос, хятадын хилийг нээсэн, Оросын Владивосток хот чөлөөт бүс болж, "Их Владивостокийн төлөвлөгөөг" боловсруулах болсон. Умард Солонгос Түмэн голын орчимд эдийн засаг ба худалдааны бүс, мөн чөлөөт усан боомт бий болгосноо зарласан зэрэг нь үүний жишээ юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төлөвлөгөөг зарлаж, 18 сарын үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлж эхэлсний дээр Япон, Өмнөд Солонгос, АНУ, Монгол зэрэг улс Түмэн голын бүсийн хөгжлийг урагшлуулах үйлст идэвхтэй хамтран ажиллах бодсныг илтгэлүүдэд тэмдэглэсэн байна.

Бүс нутгийн улсуудын дотор санал солилцон маргалдах цаг үндсэндээ шувтарч хамтран ажиллах цаг ирж, Түмэн голын төсөл хэрэгжих шатандаа шилжиж буй хэдий боловч сэтгэл түгшээсэн, шийдвэрлэгдээгүй асуудлууд ба..саар байгааг хуралд оролцогсад тэмдэглэв. Энэхүү районыг эзэмшиж эхлэхийн тулд Түмэн голын бага гурвалжинг олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс болгох Түмэн голын нэвигэцыг өргөтгөн, эргээр нь усан боомтууд байгуулах, бүсийн үйл ажиллагааг удирдах олон талын захиргааны оновчтой хэлбэрийг олох, байгаль орчныг хамгаалах гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг нь чухал болж байгааг тэмдэглэсэн болно.

Уг төслийг Хятад, Орос, Умард Солонгос гурван талаас оролдон

харилцан тохи, элцсөн хамтын зорилго, эрмэлзэх зүйлийг хэрэгжүүлэх ёстой. Энд бас гэрээ дэх тоглогч бий, тэр нь гадаадаас хөрөнгө оруулах явдал бөгөөд төслийн амжилт нь түүнээс онцгойлон хамаарна. Зохих цаг хугацаанд харилцан тохиролцсоны эцэст дөрвөн тоглогч мэргэжлийн өргөн хүрээний практик ажилд орох болно. Төслийн ирээдүй нь Ази Европыг холбосон зам харилцааны хуурай замын гүүрийг байгуулахтай холбоотойг тэмдэглэж, энэ талаар санал бодлоо илэрхийлцгээв. Ийм санал бодлын тоонд Ази, Европыг холбосон транс-азийн төмөр зам болон түүнтэй зэрэгцсэн засмал замыг Монголыг дайруулан тавих, Түмэн голын сав газарт олон улсын шинэ загварын төв хот байгуулах мэтийг дурдаж байв.

Хурлын ажиллагааг дүгнэж БНСУ ба БНХАУ-ын хоёр нэрт эрдэмтэн Бон Су Ли, Ма Бин нар үг хэлэв. Бон Су Ли хэлсэн үгэндээ: бид 3 өдрийн хуралдаанаар бүс нутгийн хөгжлийн олон чухал асуудлыг хөндөв. Бүс нутгийн потенциалыг үндсэнд нь илрүүлэн харж, эдийн засгийг хөгжүүлэх чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга замыг олсон гэж дүгнэж болно. Цаашид түүнийг биелүүлэх талаар оролдлого хийх нь чухал боллоо. Орчин үед Дорнод, Өрнөд гэж хуваах явдал угтаа алдаж эхлэв. Улс төрийн маргаан багасав. Одоо шилж сонгох боломжууд гарах боллоо. Эдийн засгийн бүс нутгууд байгуулах үйл явц эрчимжиж байна. Худалдааны салбарт хорших явдлыг хүчтэй болгох нь улс орнуудын хоорондын ялгаварлалыг арилгах чухал арга зам мөн гэв. Ма Бин хэлсэн үгэндээ: багц хурал Зүүн хойт Азийн эдийн засгийн өнөөгийн байдалд задлан шинжилгээ, дүгнэлтүүд хийв. Бүс нутгийн улс орон бүр өөр өөрийн давуу талтай, түүнээ сайтар ашиглах ёстой. Тэдгээр давуу тал нь хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмж, ажлын хүч, байгалийн нөөц зэргээр дамжин илрэх бөгөөд цаашдын хөгжлийн хүчин зүйлс болно. Бүс нутгийн хөгжил бол бид бүхний нийтийн үйл хэрэг мөн. Бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцогч улс бүр саналыг харгалзсан, бүгдийн сонирхлыг тусгасан тийм ерэнхий санал боловсруулахад бидний зорилт оршино. Одоо бүс нутгийн гурван улс БНХАУ, ОХУ, БНАСАУ хамтын чармайлтаар олсон улсын эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар оролдож байна. Энэ нь олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ көхцөлийг бүрдүүлнэ. Энэ үндсэн дээр эдийн засгийн цаашдын интеграц хэрэгжих байх. Иймээс Түмэн голын төсөл бол манай бүс нутгийн хамтын ажиллагааны нэг чухал хөтөлбөр болно. Энэ бол манай өнөөдрийн хөгжлийн хандлага юм гэв.

"Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал нь академик шинжтэй хурал болов. Хуралд бэлтгэн толилуулсан илтгэлүүд нь Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудын нийгэм, эдийн засаг, улс төрийн бодит байдал, тэдний хооронд өрнөж байгаа хамтын ажиллагаа, түүний цаашдын төлөв хандлага зэрэгт дүн шинжилгээ хийхийг оролдсон томоохон оролдлогын нэг болсон ажээ. Илтгэлүүдэд энэ бүс нутагт болж буй өөрчлөлт шинэчлэлт, нийгэм-эдийн засгийн хөгжлийн байдлыг харуулсан олон тооны тоо баримтыг оруулан хавсаргаж, тэдгээрт үндэслэн үнэлэлт дүгнэлт хийжээ. Эрдэмтдийн илэрхийлсэн бодол эрэлхийллийн гол санаа нь бүс нутагт өнөөгийн шаардлагад тохирохуйц хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэхэд зориулагдсан байна. Бүс нутгийн хоршил, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар гарсан олон үзэл баримтлал, хөтөлбөр, төслүүдийн дотор гол төсөл нь Түмэн голын төсөл болж багаа нь хурлын ажиллагаанаас харагдаж байна.

Үүнээс үзэхэд Владивостокийн хурал нь шинжилгээ судалгааны чухал хэрэглэгдэхүүнийг буй болгов. Эдгээр хэрэглэгдэхүүнийг манай эрдэм шинжилгээ, практик байгууллагуудад судлах нь тус улсаас Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудтай харилцах, тэнд бүрэлдэж буй эдийн засгийн олон талын хамтын ажиллагаанд ажил хэрэгчээр оролцох асуудлыг шийдвэрлэхэд тус болохуйц шинэ нэмэгдэл үзэл санааг олж авахад тус нэмэр болох билээ.